

Монгол

Хүн ам	2.8 сая
Хүн амын өсөлт	1.5 хувь
ДНБ	26.8 тэрбум
1 хүнд ноогдох ДНБ	9,433
Газар	1,564,120 км ²
Нийслэл	Улаанбаатар

Эх: Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд

Дүгнэлт

Хэдийгээр эдийн засгийг өргөжүүлсэн бодлогуудыг гаргасан ч 2014 онд Монголын эдийн засаг удааширсан байна. Өнөөгийн эдийн засгийн удаашрал нь өндөр инфляци болон чанга төлбөрийн балансын дарамтын хариуд эдийн засгийн зохицуулалт хийсэнтэй холбоотой юм. Урсгал дансны алдагдал 2014 онд нилээд хэмжээгээр багассан боловч ШХО-ын томоохон цоорхой нь төлбөрийн балансын алдагдлын хэмжээг их байлгаснаар олон улсын нөөц болон ханшын үнэлгээнд ихээхэн дарамт учруулж байна. Ханшийн бууралт болон эдийн засгийг тэлэх бодлогийг үргэлжлүүлснээр инфляцийн түвшинг 2 оронтой тоонд оруулсан. Эдийн засгийн өсөлтийг сүүлийн 3 жилд 2 оронтой тоонд барьж байсан дэлхийн ашигт малтмалын зах зээлийн чийгшил болон эдийн засгийг тэлэх бодлого нь эдгээр эдийн засгийн тэнцвэргүй байдлыг үүсгэсэн юм. Эдийн засгийн бодлогын үндсэн зорилго нь дотоод, гадаад эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, эмзэг нөхцөл байдал бий болохоос урьдчилан сэргийлэхэд оршдог. Эдийн засгийн ойрын хүндрэлүүдийг арилгаж, санхүү болон төсвийн эрүүл байдлыг хадгалахын тулд мөнгөний болон төсвийн бодлогыг чангалах шаардлагатай юм. Мөн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаанд үүнтэй адил чармайлтыг гаргах хэрэгцээтэй байна.

Сүүлийн үеийн эдийн засгийн нөхцөл байдлууд

Монголын эдийн засгийн өсөлт 2013 оны 2-р улиралд 14.4 хувьтай харьцуулахад 2014 оны 1-р улиралд 5.3 хувь болж буурсан. Хэдийгээр ашигт малтмалын ДНБ-ний өсөлт 1-р улиралд 16.1 хувьтай байсан бол ашигт малтмалын бус ДНБ-ний өсөлт 2.8 хувь болтол буурчээ. Өндөр инфляци болон ханшийн бууралтын үргэлжлэлээс үүдэн дотоодын эрэлт нилээдгүй дарамтанд орсон. Үйлдвэрлэлийн гарц 0.3 хувиар өсч, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 12.3 хувиар багассан нь дотоодын эрэлт суларсныг харуулж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын орчингийн тодорхойгүй байдлын үед эдийн засгийн өсөлтийн зардлын хувьд эдийн засгийн гол удаашралын шалтгаан нь хөрөнгө оруулалт дахь 32.4 хувийн цоорхой юм. 2014 оны 7 сард инфляци үндэсний хэмжээнд 14.9 хувьд хүрсэн. Ханшийн уналт болон эдийн засгийг тэлэх бодлогоор дамжуулан мөнгөний бодлогын зөөлрүүлэлт болон Монголын хөгжлийн банкаар дамжуулан төсвийн гадуурх зарцуулалт хийх нь үнийн түвшинд ихээхэн дарамт үзүүлсэн. Эрэлтийн талын дарамтыг тусгадаг цөм инфляци 2013 оны эцэст 12.1 хувь байсан бол 2014 оны 7 сард 17.9 хувь болж өсжээ.

Худалдааны алдагдал багассанаас үүдэн урсгал дансны алдагдал 2014 оны 1-р улиралд эрс багассан байна. Энэ оны эхний хагас жилийн урсгал дансны баланс 603 сая

ам.долларын алдагдалтай гарсан байгаа нь өмнөх оны дүн болох 1,607 сая ам.доллартай харьцуулахад эрс буурсан байна. 1 сараас 6 сарын хоорон дахь худалдааны данс 35 сая ам.долларын (ФОБ) илүүдэлтэй байсан бол энэ нь өмнөх оны 756 сая ам. долларын алдагдлаас эрс сайжирсан байна. 2014 оны эхний 7 сард шинэ Оюу толгой уурхайн зэсийн экспортын өсөлт 150 хувьд хүрсэнтэй холбоотойгоор нийт экспорт 24.9 хувиар өсжээ. Мөн, машин техник, тоног төхөөрөмжийн импорт 41.7 хувиар буурсан нь хөрөнгө оруулалтын хэмжээ буурч байгааг харуулж байгаа ба үүний улмаас нийт импорт 14.6 хувиар буурчээ.

Урсгал алдагдал буурч байгаа ч гадаад хөрөнгийн орлогын урсгалын бууралтаас болж төлбөрийн баланс дахь дарамт өндөр хэвээр байна. 2014 оны 1-р улиралд хөрөнгө, санхүүгийн данс 29.8 сая ам. долларын илүүдэлтэй байсан нь 2013 оны тухайн үеийн 914 сая ам.долларын илүүдэлтэй харьцуулахад огцом уналт юм. 1-р улирлын Цэвэр гадаад шууд хөрөнгө оруулалтын орлогын урсгал 370 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оныхоос 70 хувиар буурсан үзүүлэлт юм. Хэдийгээр урсгал дансны алдагдал багассан ч хөрөнгө, санхүүгийн дансны бага илүүдлийн улмаас нийт гадаад санхүүжилтийн зөрүү их хэвээр байна. Нийт гадаад санхүүжилтын зөрүү 2013 оны 1-р улирлаар 983 сая ам.доллар байсан бол 2014 оны 1-р улиралд бага хэмжээгээр багасч 915 сая ам.доллар буюу жилийн ДНБ-ний 7-8 хувьтай тэнцүү болжээ.

Төлбөрийн баланс дахь их хэмжээний санхүүжилтын зөрүү нь олон улсын нөөцийн түвшин болон ханшид жилийн турш үргэлжилсэн уналтыг авчирсан. Төв банкны нийт олон улсын нөөц 2014 оны 7 сард 1.2 тэрбум ам.доллар хүртэл буурсан нь өмнөх оны 3.1 тэрбум ам.доллартай харьцуулахад 58 хувиар, 2012 оны 12 сарын оргил цэг болох 4.1 тэрбум ам.доллартай харьцуулахад 70 хувиар буурсан байна. Дотоодын ханш сүүлийн 12 сард 24.8 хувиар буурч, жилийн эхний 7 сард 13 хувиар буурчээ.

Төлөв, үүсэх хүндрэлүүд

Монголын эдийн засгийн урт хугацааны төлөв нь байгалийн нөөцийг авч үзвэл ирээдүйтэй байгаа боловч ойрын хугацаанд яаралтай шийдвэрлэх эдийн засгийн хүндрэлүүд байна. 2014 онд Монгол улсын эдийн засаг сүүлийн 3 жилийн турш хуримтлагдсан их хэмжээний эдийн засгийн тэнцвэргүйжүүлэлтээс бий болсон дарамтан дор байна. Ашигт малтмалын бус салбарын өсөлт сул байгаатай холбоотой 2014 оны жилийн эдийн засгийн өсөлт 6.3 хувьтай байхаар таамаглаж байна. Инфляцын түвшин ирэх саруудад 2 оронтой тоонд хэвээр байна. 2014 онд зэсийн экспорт сайжирч, импортын эрэлт сулрахтай холбоотой урсгал дансны алдагдал 2013 оныхтой харьцуулахад 25 хувиар багасч, ойролцоогоор ДНБ-ний 14 хувьтай тэнцүү байна. Гэвч, төлбөрийн балансын дарамт өндөр хэвээр байх бөгөөд энэ нь олон улсын нөөцөд их хэмжээний дарамт үүсгэнэ. Хятадын Ард түмний банктай хийсэн 15 тэрбум Юаны 2 талт гэрээ нь багасч буй олон улсын нөөцөт тодорхой хэмжээний буфер бий болгоно. Гэвч, одоогийн эдийн засгийн нөхцөл нь эдийн засгийг эрчимжүүлэх бус тогтвортой байдалд хүргэх бүтцийн өөрчлөлт хийхийг шаардаж байна.

Эдийн засгийн бодлогын үндсэн зорилго нь дотоод, гадаад эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Ойрын эдийн засгийн хүндрэлүүд болон санхүү, төсвийн эрүүл байдлыг хангахын тулд мөнгө, төсвийн бодлогуудыг чангатгах шаардлагатай байна. Мөн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаанд үүнтэй адил чармайлтыг гаргах хэрэгцээтэй байна. Ялангуяа, ГШХО-ыг сэргээж чадсан

тохиолдолд эдийн засгийг аюулд оруулалгүйгээр хөрөнгө оруулалт сэргэж, ажлын байр нэмэгдэх юм. Эдийн засгийн бодлого чангарч байгаа шинж тэмдэгүүд мэдрэгдэж байгаа боловч өндөр инфляцын түвшин, их хэмжээний төлбөрийн балансын дарамттай тэмцэхэд илүү их чармайлт гаргах шаардлагатай байна. Монгол банк бодлогын түвшнээ 7 сард 150 пойнтоор нэмж, зарим шаардлагатай банкны журмыг чангатгахаар зарласан. Гэвч, төв банкны хөрвөх хөрөнгөд найдсан бага хүүтэй орон сууцны санхүүжилт цаашид үргэлжлэхээр байна. Мөн, Үнийн тогтвортой байдлыг хангах хөтөлбөрийн доор мөнгөний удирдлагаас олгосон бодлогын зээлүүдэд хүлцэнгүй байдлыг зөвшөөрсөн журмыг устгах зэргээр банкны салбарын журам, хяналтыг цаашид чангатгах шаардлагатай. Хэдийгээр өнгөрсөн жилийн төсөвтэй харьцуулахад албан төсвийг чангатгаж, төсвийн гадуурх зарцуулалтын хэмжээ багассан ч төсвийн бодлогын тэлэлт хэвээр байна. Монголын Хөгжлийн банкаар дамжуулан зарцуулж буй их хэмжээний хөрөнгө нь албан төсвөөс гадуур хэвээр байгаа ба төсвийн алдагдал болон МХБ-ны зарцуулалт 2014 онд ДНБ-ий 7 хувиас дээш байна. МХБ-ны зарцуулалт болон бүх төсвийн зарцуулалтыг нэгтгэн төсөвт суулган, ирэх жилүүдийн нэгтгэсэн бүтцийн төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу 2 хувь хүртэл бууруулах дунд хугацааны зохистой төсвийн нэгтгэсэн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай.

Монгол: Үндсэн үзүүлэлтүүд					
	2012	2013г	2014г	2015г	2016г
	Жил	Жил	Жил	Жил	Жил
Гарц, Хөдөлмөр эрхлэлт, Үнэ					
Жинхэнэ ДНБ (жилээс жил дэх өөрчлөлт) ¹	12.4	11.7	6.3	6.2	6.6
Ашигт малтмалын ДНБ (%)	8.3	19.4	12.9	11.6	6.2
Хэрэглэгчийн үнийн индекс (жилээс жил дэх өөрчлөлт)	14.2	12.3	13.2	11.1	8.0
Улсын салбар					
Засгийн газрын орлого (ДНБ-д эзлэх %)	29.7	31.0	28.2	27.9	26.8
Засгийн газрын зарлага (ДНБ-д эзлэх %)	39.8	40.3	35.3	33.1	30.1
Засгийн газрын баланс (ДНБ-д эзлэх %) ²	-10.1	-9.3	-7.1	-5.2	-3.3
Нийт улсын салбарын өр (ДНБ-д эзлэх %)	51.3	58.1			
Гадаад худалдаа, Төлбөрийн баланс, Гадаад өр					
Худалдааны баланс (сая ам.доллар)	-1553	-1303	-126	68	-146
Бараа, таваарын экспорт (сая ам.доллар)	4385	4273	4920	5523	5958
(жилээс жил дэх өөрчлөлт)	-9.0	-2.6	15.1	12.3	7.9
Бараа, таваарын импорт (сая ам. доллар)	5938	5576	5046	5455	6104
(жилээс жил дэх өөрчлөлт)	2.2	-6.1	-9.5	8.1	11.9
Урсгал дансны баланс (сая ам.доллар)	-3362	-3156	-1710	-1676	-2064
(жилээс жил дэх өөрчлөлт)	-27.4	-25.1	-13.9	-12.5	-13.7
Гадаад шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар)	4407	2342			
Гадаад валютын нөөц, нийт (сая ам.доллар)	4126	2242			
(Бараа, үйлчилгээний сарын импорт)	6.4	3.5			
Санхүүгийн зах зээл					
Дотоод зээл (жилээс жил дэх өөрчлөлт)	24.1	54.3			
Нөөцийн мөнгө (жилээс жил дэх өөрчлөлт)	30.5	54.0			
Богино-хугацаат хүү (%) ³	13.3	10.5			
Валютын ханш (Төгрөг/ам.доллар)	1392	1674			
Бодит валютын ханш (2000=100)	140.0	136.4			
(жилээс жил дэх өөрчлөлт)	5.1	-2.5			
Хөрөнгийн зах зээлийн индекс (12 сар.2000=100) ⁴	17714	16736			
Тэмдэглэл: нэрлэсэн ДНБ (сая ам.доллар) ⁵	12.3	12.5	12.3	13.4	15.1

¹ 2014 оноос өмнөх бодит ДНБ-ний тооцоолол нь 2005 оны үнэд суурилсан. 2014-2016 оны ДНБ-ний тооцоолол нь 2010 оны үнэд суурилсан.

² Засгийн газрын зарлага, үлдэгдэлд МХБ-ны төсвөөс гадуурх зарцуулалт багтана

³ Суурь бодлогын түвшин

⁴ Топ-20 Индекс

Эх: Монгол банк, Үндэсний статистикийн газар, Сангийн яам, ОУВС, ДБ
г= гүйцэтгэл
т= таамаглал
б&γ= бараа, үйлчилгээ

⁵ Нэрлэсэн ДНБ-ний тооцоолол нь 2014 оны 8 сард Үндэсний статистикийн газраас гаргасан шинэ түүхэн мэдээлэлд суурилсан